

“Монгео” ХК-ийн 2019 оны Үйл Ажиллагааны Тайлан

Компани нь тайлант хугацаанд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны баталсан журам, компанийн дүрэм болон дотоод журам, компанийн өмнөх оны Хувь Нийлүүлэгчдийн Хурлын болон ТУЗ-ийн хурлын шийдвэрийг биелүүлэн ажиллах зорилгыг баримтлан үйл ажиллагаа явуулсан юм.

“Монгео” ХК “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-тай Үнэт Цаасны хадгаламжийн гэрээг хууль журамд заасан хугацаанд байгуулан, төлбөр тооцоог хийн хамтран ажиллаж байв.

Мөн Санхүүгийн Зохицуулах Хороо, Хөрөнгийн Бирж-тэй хамтран ажиллаж байна.

Тус компанид 18 ажиллагсдын орон тоотойгоос 2019 онд 8 хүн орон тоогоор ажиллаа. Үүнд: ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал, Менежер, Зохион байгуулагч, Үйлчлэгч, Харуул, 3 хүн ажиллаж байна.

Компанийн ажиллагсад өөрсдийн ажил үүргийн дагуу сар бүр ажлаа төлөвлөн ажиллаж биелэлтийг сар бүрийн эцэст хурлаараа дүгнэн ажилладаг болно. Сар бүр НДШ төлөлтийн тайланг хугацаанд нь тайлагнаж тооцоог хийн ажиллаж байна.

Тус компани үндсэн үйл ажиллагааны “Барилгын зураг төсөл, Геодези зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, Кадастрын зураглал, Геологийн судалгаа явуулах, Гадаад худалдаа, худалдааны зуучлал” –ын чиглэлээрээ үйл ажиллагаагаа явуулахгүй зөвхөн түрээсийн үйл ажиллагааг эрхэлж байгаа билээ.

Манай компани 12-272 мкв талбай бүхий өрөөнүүдийг 8 аж ажуй нэгж, хувь хүнд түрээслэн ажилладаг.

Сар бүрийн 20-25 ны хугацаанд төвлөрдөг түрээсийн орлогыг ажиллагсдын цалин бүх төрлийн татварыг боломжоороо төлөх үйл ажиллагаанд, хэрэглэж буй цахилгаан ус, дулааны төлбөрт зохицуулан хуваарилж зарцуулдаг болно.

Тайлант хугацаанд түрээсийн үйл ажиллагаанаас / 92.887.906 /төгрөгийн орлого төвлөрүүлснээс хэрэглээний цахилгаан, дулаан, ус, НДШимтгэл, ажиллагсдын цалин, зээл зээлийн хүү, байгууллагын бусад үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг төлж барагдуулах ажлыг гүйцэтгэдэг боловч нийт зардалдаа хүрдэггүй юм.

Иймээс НӨАТ болон бусад татварын өр үлддэг. Энэ нь алдагдалтай ажиллах үндэс нь болдог.

2019 онд компани санхүү татварын тайлангуудыг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад нь тайлагнаж ирлээ. ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн зохих

шаардлагыг хангасан, тусгай зөвшөөрөлтэй “БИ ЭНД СИ Аудит” ХХК-иар санхүүгийн тайлангаа хянуулж дүгнүүлсэн.

Өнгөрсөн оны Хувь Нийлүүлэгчдийн Хурлаас гаргасан шийдвэрүүдийг боломжит байдлаар нь биелүүлэн ажиллалаа.

Өнгөрсөн оны эцэст тус компаний байранд 12-64 мкв талбай бүхий оффисийн зориулалтаар ашиглаж болох 6 өрөө сул , ашиглалтгүй байна.

Компанийн үйл ажиллагаа түрээслэх ажиллах байгаа тул сул өрөөнүүдийг түрээслэх тал дээр гүйцэтгэх удирдлага , ТУЗ зохих арга хэмжээ авахад идэвхитэй оролцох хэрэгтэй байна.

Бид сул байгаа өрөөнүүдийг түрээслэж чадвал сар бүр гарах зардлаа төлөөд ашигтай биш гэхэд алдагдал багатай ажиллах нөхцөл бүрдэх юм.

Компани он дамнасан НӨАТ-ийн /6287296.60/ , /ХХОАТ 3020999.98/ төгрөг байна.

Хурлаас зохих шийдвэр гарган эдгээр өрүүдийг төлж барагдуулах асуудлыг зохион байгуулах шаардлагатай байгаа юм. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх , үнэт цаасны зах зээлийг судлах , дахин хувьцаа гаргах замаар санхүүгийн чадамжийг өсгөх, хөрөнгө оруулалт болон гадаад харилцааг судлах зэрэг ажлыг хариуцах эзэнтэй ,тодорхой хугацаатайгаар хийж гүйцэтгэхэд ТУЗ-ийн дарга , гишүүд, компанийн менежер, нябо нар идэвхи зүтгэл гарган ажиллах шаардлагатай байна.

Хурлаас гарах санал ,тогтоол, шийдвэрүүдийг хүндэтгэн үзэж хүлээн авч компанийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах болно.



КОМПАНИЙН ЗАХИРГАА